

# ХУУЛЬ ХЭРХЭН БҮТДЭГ ВЭ?



## Зорилт:

- Улсын Их Хурлын хууль батлах үйл явцыг зураглан харуулах, тайлбарлах



## Сэдвийн агуулга:

- Хууль санаачлах
- Хуулийн төсөл
- Хуулийг хэн, хэрхэн баталдаг вэ?

## Сургалтын арга:

- Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны зураглалыг хийх
- Багаар ажиллах

## Хичээлийн хэрэглэгдэхүүн:

- "Хууль хэрхэн бүтдэг вэ?" видео

## Түлхүүр үг:

### Хууль

Нийгмийн харилцааг зохицуулахын тулд парламентаас батлан гаргасан, бүх нийтээр заавал дагаж мөрдөх ёстой эрх зүйн хэм хэмжээ. Монгол Улсын хуулийг зөвхөн Монгол Улсын Их Хурал ард түмний нэрийн өмнөөс батлан гаргадаг.

### Хэлэлцүүлэг

Хууль хэлэлцэн батлах үйл ажиллагааны нэг шат.

### Хуулийн төсөл

Хууль санаачлагчаас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн эх бичвэр.

### Хууль тогтоох

Хуулийн төслийг хэлэлцэж, батлах үйл ажиллагаа. Хууль тогтоох үйл ажиллагааны үе шат, дарааллыг парламентын дэгийн тухай хуулиар тогтоодог.

### "Төрийн мэдээлэл" эмхэтгэл

Хууль, Улсын Их Хурлын тогтоолыг албан ёсоор нийтэлдэг эмхэтгэл.

## Үйл ажиллагаа

### 1. Сэдэлжүүлэлт

- Сурагчдаас хууль гэж юу болох, хэрхэн бүтдэг, яагаад шинэ хууль бүтээх хэрэгтэй талаар өмнөх мэдлэгийг сонсоно.

### 2. Шинэ мэдлэг бүтээх

- Сурагчийн гарын авлагаас "Хууль хэрхэн бүтдэг вэ?" сэдвийг сурагчидтай хамтдаа уншина.
- Уншиж дууссаны дараа самбар дээр сурагчдын хамт хуулийн төслийн аяллын бүхий л үе шатыг ярилцаж тэмдэглэнэ.

### 3. Бататгал

- Дасгал ажлын хуудсыг хувилаад сурагчдад тарааж өгнө.
- Дасгалыг хэрхэн хийх зааврыг танилцуулж, гүйцэтгэх хугацаа олгоно.

### Дасгал ажил 1.






"Хуулийн төслийн аялал" дасгалын хуудсан дээрх зургийг хайчлан авч, зөв дараалалд оруулуулна. Үүний дараа сурагчдаар хуулийн төсөл хууль болох аяллын талаар тайлбарлуулна.

### Хяналтын асуулт:

- 1.Хуулийн төслийг хэн санаачилдаг вэ?
- 2.Хуулийн төслийн аяллын үе шат бүрд юу юу хийснийг тодорхойлно уу.
3. Яагаад эдгээр үе шатыг дамждаг юм бол?

Дасгал ажил 1.

# Хуулийн төслийн аялал



ТАРИМЭНТЭЙН  
**БОЛОВСРОЛ**



Зургийг хайчилж аваад зөв дараалалд оруулаарай.